



hunnu.asia [hunnuconcrete](https://www.facebook.com/hunnuconcrete) info@hunnu.asia 93090906 93090908 77017575

Central Tower, Great Chingis Khan square,
Sukhbaatar district, 8th khoroo, 9th floor, 903



Дэлхийн Стандартыг Монголд...



Bring World Standard in Mongolia...



Үндэсний томоохон бүтээн байгуулагчдын нэг болох **ТЭСО** корпорацийн охин компани болох “Хүннү конкрет” ХХК 2011 онд албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Өнөөдрийг хүртэл улсын болон хувийн томоохон төслүүд дээр ажиллаж туршлага хуримтлуулан, үйл ажиллагаа маань жилээс жилд тэлсээр байна.

Сүүлийн жилүүдэд салбартаа өөрийн байр суурийг бататгаж ажиллах хүчээ нэмэгдүүлэн ажиллаж 2015-2016 онд салбартаа тэргүүлэх хэмжээний авто баазыг бий болгож харилцагчийн хэвийн нийлүүлэлтийг цогцоор нь шийдэж өгсөн **“Анхны компани”** болсон.

ТЭМ –ийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхдээ олон улсын стандартуудын дагуу олон удаагийн туршилт шинжилгээнээс үндэслэн үйлдвэрлэлдээ нэвтрүүлдэг боллоо. Канад, Америк, ОХУ гэх мэт хэд хэдэн улсын мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж тэдгээрээс шинэ, шинэлэг техник технологийн мэдээллийг цаг алдалгүй авч эдгээр улсын стандартуудыг өөрийн улсдаа нутагшуулах цаашлаад монгол улсад хийгдэж байгаа бүтээн байгуулалтад өөрсдийн мэдлэг туршлагыг ашиглан, байгаль орчинд ээлтэй, чанар стандартыг бүрэн хангасан, орчин үеийн тоног төхөөрөмжийн тусламжтайгаар үйлдвэрлэсэн бетон зуурмагийг зах зээлд нийлүүлж, бидний хойч үе болсон оюутан залуусынхаа боловсролд эзэмшүүлэхийн зэрэгцээ монгол улсад олон улсад зөвшөөрөгдсөн шинэ стандартыг бий болгох хэтийн зорилготой ажиллаж байна.

Established in 2011, "Hunnu Concrete" LLC, subsidiary of "Teso Corporation" company, is one of the largest and fastest growing businesses in Mongolia, and has participated in both major public and private projects. Our operation continues to grow year by year.

In recent years, we have been working to strengthen our position in the industry. From 2015 to 2016, we had become the Top Company in the industry by establishing a leading vehicle base in the concrete industry. In order to choose high quality raw materials, we do numerous test based on international standards.

Cooperating with concrete associations of several countries, such as Canada, USA, China and Russia, we introduce innovative technology and standards to gain experience and to contribute to the development of Mongolia. With our leading experience, we want to supply eco concrete, want to contribute to education, and want to set international standard in Mongolia.

АЛСЫН ХАРАА

Дэлхийн Стандартыг Монголдоо

ЭРХЭМ ЗОРИЛГО

Шинэчлэгдэгч мэдлэгийн үрээр бүтээмжид чиглэж, хүнээ дээдлэн, ухамсарт соёлыг төлөвшүүлэгч байгууллага байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

Бид үргэлж хуулийн ажилладаг. Хэрэглэгчдэд зөвхөн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийг эрхэм үүргээ гэж үздэг. Аливаад өөриймсөг ханддаг, ёс зүйтэй, мэргэшсэн ажилтнууд ХҮННУ КОНКРЕТ-ийн үнэт зүйл байх болно.

VISION

To Set International Standard in Mongolia

MISSION

Our culture blossoms employee respect, productivity and ideation.

VALUE

We always operate under the law. Our main goal is provide high quality products to our customers. Employees with high ethic and skill are core value of Hunnu Concrete.



ЧАНАР СТАНДАРТ / QUALITY

- Чанарын стандарт хангасан бүтээгдэхүүн
Products meeting international standard
- Эко бетон үйлдвэрлэл
Eco concrete production
- Давхар шалган батлагдсан түүхий эд, бүтээгдэхүүн
Double tested raw materials

ТУРШЛАГА / EXPERIENCE

- Мэргэшсэн туршлагатай баг хамт олон
Highly experienced employees
- Салбартаа тэргүүлэгч шилдэг “Авто бааз”
Fully equipped vehicle base
- Алсаа харсан шийдвэрүүд
Long term based decisions

ХАРИУЦЛАГА / RESPONSIBILITY

- Алдаа дутагдлын байнгын сайжруулалт
Continuous improvement to fix mistakes
- Хөдөлмөр аюулгүй үйл ажиллагааны томоохон системтэй
HSE quality
- Зөв хандлагатай дотоод соёл
Culture with positive attitude
- Итгэл даах, хариуцлагатай, зарчимч хамт олон
Responsible organization with integrity

ХАРИЛЦАА ХОЛБОО / COMMUNICATION


- Цахим хяналтын систем
Online financial analytical system
- Нээлттэй харилцаа холбоо
Open communication
- Найдвартай түнш, ханган нийлүүлэгч
Reliable supplier
- Харилцагчдад зориулсан урамшуулалт хөтөлбөр
Promotions for clients
- Харилцагч байгууллагын талбайн инженерт станц өгснөөр хүссэн үедээ манай үйлдвэртэй шууд холбогдох боломж
Radio Station - Client company site engineer can contact directly to our factory anytime.
- GPS Богино долгион станцаас гадна, миксер бүрийг хаана явааг шууд ситемээс хянах боломжтой
GPS system- In addition to shortwave stations, mixers can be monitored directly from the system
- Харилцагчийн санхүүгийн чадамжтай уялдсан төлбөрийн шинэлэг саналууд
Tailored payment options

ХӨГЖИЛ ДЭВШИЛ / IMPROVEMENT

- Ур чадварын байнгын сайжруулалт
Continuous improvement of skill set
- Proceq иж бүрэн явуулын лаборатори
Mobile laboratory service equipped with “Proceq” products
- Олон улсын эксперт зөвлөх инженерүүд
Experienced international advisors
- Орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж
Modern advanced equipment
- Бохир ус дахин ашиглах системийг бий болгосон
Water recycling system
- Дэлхийн сүүлийн үеийн чиг хандлага
International Standards and Innovative Technology Training Seminars
- Станцын хаягдал үнс үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн
By using fly ash, we improved quality of the concrete
- Жолооч нар байнгын богино долгионы станцаар шууд холбогдож, түргэн шуурхай үйлчлэх боломж
Shortwave station - Drivers can connect to anyone, anytime.
- Судалгааг байнга явуулснаар үйлчилгээгээ сайжруулж ажилладаг
tSurvey - To continuously improve customer service



Бетон зуурмагийг үйлдвэрлэхээс эхлэн харилцагчдад нийлүүлэх хүртэлх үе шатын процессын зураглал / Process of concrete plant



Чанарын тестлэлийн шатлалын зураг /Quality test levels

PROCEQ БРЭНД

Үйлдвэрийн лабораторийг цаг бүр шинэчилж, дэлхийд тэргүүлэгч эко бетон зуурмаг үйлдвэрлэхэд чухал түлхэц өгдөг **“Proceq”** брендийн багаж төхөөрөмжийг 2016 онд үйлдвэрийн лабораторидоо амжилттай нэвтрүүлж чадсан билээ. Шинэ шинэлэг тоног төхөөрөмжийг тогтмол нэвтрүүлж эхэлснээр технологийн ажилчдынхаа мэдлэг боловсролыг нэмэгдүүлж байдаг. Мөн энэхүү брендийн тоног төхөөрөмж дээр мэргэшсэн ажилчдынхаа саналын хүрээнд явуулын лабораторийг бий болгож чадсан. Энэхүү лаборатори нь бүхий л үед таны үнэнч зөвлөгч байх болно.

- ✓ Дэлхийд танигдсан бренд
- ✓ Дэвшилтэт тоног төхөөрөмж
- ✓ Сургалт семинар
- ✓ Хамтарсан үзлэг шинжилгээ
- ✓ Олон улсын стандарт

PROCEQ BRAND

The **“Proceq”** brand equipment was successfully introduced in 2016 into our laboratory, which is important to the quality of the world-class eco-concrete. By constantly introducing latest technology, we improve product quality and employee skills. In addition, we have set up a mobile laboratory fully equipped with expert technicians. Laboratory technicians visit to client's job site and give advice on the field.

- ✓ Globally Recognized Brand
- ✓ Latest Technology
- ✓ Training Seminars
- ✓ Joint Research and Examination
- ✓ International Standard

УС ДАХИН АШИГЛАХ

Улс орон бүрд анхаарлын төв цэгт байгаа цэвэр усны хомстлын асуудалд мэргэжилтнүүд чухал ач холбогдол өгч хэрэглээг танах шинэ шинэлэг санал санаа өдрөөс өдөрт судлан гаргаж туршиж байгаа энэ үед дор бүрнээ боломжит нөхцөлийг хайн судалж хэрэгжүүлэх нь бидний хүлээсэн нийгмийн хариуцлага гэж үздэг. Тиймээс ч манай компани усыг дахин ашиглах технологийг судлан үйлдвэрлэлдээ нэвтрүүлэх ажилдаа орлоо. Бетон зуурмагийн үйлдвэр жилд дунджаар 5,000 – 28,000 шоо метр ус ашиглаж зуурмаг үйлдвэрлэдэг. Харин үүнийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлснээр жилд 500-1,200 шоо метр гүний усыг хэмнэх боломжтой болж байгаа юм.

- ✓ Нийгмийн хариуцлага
- ✓ Сул зардлыг бууруулах
- ✓ Байгаль орчинд ээлтэй

WATER RECYCLING SYSTEM

Globally, shortage of water is growing problem and water recycling system is our social responsibility. Therefore, we are about to introduce this system. Average Mongolian Concrete Batching Plant uses about 5,000 - 28,000 m³ water per year. However, it is possible to save at least 500 - 1200 m³ annually.

- ✓ Social Responsibility
- ✓ Cost Saving
- ✓ Environmentally Friendly

ХАЯГДАЛ ҮНС

4-р цахилгаан станцын багануурын нүүрсний үнсийг ашиглаж B25 маркын цементэн бетоны үзүүлэлттэй тэнцүү хэмжээний өндөр бат бэхтэй шинэ бетон зуурмаг гарган авах боломжтой бөгөөд эдийн засгийн хувьд бодит үр ашигтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой юм. Байгальд ээлтэй энэхүү төслийг хэрэгжүүлснээр бетон зуурмагийн чанарыг олон удаагийн туршилт шинжилгээнд үндэслэн өндөр бат бэх –ийн үзүүлэлтийг гарган авах боломжтой байдаг. Олон улсад үнсийг бетон зуурмагт орж буй цементийн 50% хүртэлх хэмжээнд ч хэрэглэж байна гэсэн судалгаа байдаг.

- ✓ Байгальд орчинд ээлтэй
- ✓ Бетон зуурмагийн насжилт уртасна
- ✓ Эдийн засгийн хувьд үр өгөөжтэй
- ✓ Шинэлэг технологи

WASTE ASH / FLY ASH /

The Thermal Power Plant 4's fly ash can be used to produce strengthened concrete equal to B25-grade, and it's cheaper than cement. By implementing this environmentally friendly product, we both save cost and improve quality. In some countries fly ash can be used up to 50% of cement ratio.

- ✓ Environmentally Friendly
- ✓ Increased Durability
- ✓ Decreased Cost
- ✓ New Technology

ЯВУУЛЫН ЛАБОРАТОРИ


Бид бүрэн тоноглогдсон явуулын лабораторитой автомашинаар бетон зуурмаг цутгалт авч байгаа, цутгалтын явцад хүндрэлд орсон, бетоны дараах арчилгаа гэх мэт бүхий л тулгамдсан асуудалд 24/7 –ын хугацаанд дуудлагын дагуу очиж анхан шатны үзлэгүүдийг хийж шаардлагатай зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч хамтран ажиллана. Мөн манайхаас багц үйлчилгээ авч болох ба энэ нь тогтсон хугацааны дагуу тухай бүрд очиж үзлэг шинжилгээ, зөвлөгөө, дээж авч шалгах, бетоны арчилгаан зааварчилгаа, бэхжилтийн явц тодорхойлох зэрэг бүхий л үйлчилгээг нэг доор авах дүгнэлт гаргуулах бүрэн боломжтой. Танд тусгай үйлчилгээ үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

- ✓ Чанар стандарт тодорхойлох
- ✓ Тусгай үйлчилгээ үзүүлэх
- ✓ Сургалт семинарт оролцох
- ✓ Шинэ шинэлэг мэдээ мэдээллийг тогтмол хүргэх

MOBILE LABORATORY

Our fully equipped mobile laboratory can test all procedures of concrete on site, and provides regular advice 24/7. Also, it's included in our package so that a client gets all laboratory services, including inspection, consulting, sample testing, and concrete maintenance, tracking process. I'm sure you'll enjoy this special service.

- ✓ Quality Control
- ✓ Special Services
- ✓ Seminar, Training
- ✓ Regular Advice on Latest Trends



КАРЬЕР (Дархан)

MNS стандартад бүрэн нийцсэн хайрга, дайрга, элсийг үйлдвэртээ нэвтрүүлэн ашиглана.

- ✓ Бетон зуурмагт нөлөөлөх чанарын үзүүлэлт өндөр
- ✓ MNS стандарт
- ✓ Тасалдал үүсэхгүй

AGGREGATE FACTORY (Darkhan city)

Gravel and sand that are fully compliant with Russian & Mongolian standards.

- ✓ Off Products Quality
- ✓ Higher Quality
- ✓ Non-stop Supply



Дайрга / Aggregate supply



Элс /Aggregate supply

ТӨМӨР ЗАМ


Бетон зуурмагийн цогц үйлдвэрийг бий болгохыг зорьсон манай компани үйлдвэртээ дэд бүтэц буюу төмөр замын асуудлыг зөв шийдэж чадсан. Ингэснээр гол түүхий эд болох дүүргэгч материал, холбогч материал зэрэг материалуудын татан авалтын хугацаа жигд буюу тасалдалгүй болж бүтээгдэхүүн эцсийн хэрэглэгчиддээ захиалгын дагуу нийлүүлэгдэх болно. Алсыг харсан бодлого маань ч үр өгөөжөө өгөөд эхэлсэн нь бидэнд улам их урам зоригийг өгөөд байна.

- ✓ Дэд бүтцийн зөв шийдэл
- ✓ Алсын хараа
- ✓ Логистикийн зөв шийдэл
- ✓ Эдийн засгийн үр өгөөжтэй
- ✓ Хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн

RAILWAY

We wanted to build complete concrete batch plant: solved infrastructure and railway problems. In doing so, main raw material will continue to be accessible for us during peak season.

- ✓ Great Infrastructure
- ✓ Vision
- ✓ Logistics Solution
- ✓ Economically Beneficial
- ✓ Ease of Work



ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА


Америк , Канад , ЗХУ –аас салбартаа тэргүүлэгч экспертүүдийг эх орондоо урьж авчран ажилчидтайгаа туршлага солилцуулж хамтын туршилт шинжилгээг олон янзаар хийж үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгоод байна. Удахгүй бид шинэ шинэ технологи, бүтээгдэхүүнийг цаг алдалгүй улсдаа нэвтрүүлж мэдээ мэдээллийг дэлгэрэнгүй хүргэх сургалт семинарыг тогтмол зохион байгуулах болно. Энэ нь улсдаа оруулж буй томоохон оюуны, технологийн ололт амжилтын хөрөнгө оруулалт байх болно.

- ✓ Олон улсын стандарт
- ✓ Хөгжил
- ✓ Ажилчдын өндөр боловсрол
- ✓ Хамтарсан сургалт семинар
- ✓ Нийгмийн хариуцлага

INTERNATIONAL COOPERATION

Experts from USA, Canada and Russia visit to exchange experiences with our employees and cooperate in a variety of collaborative experiments. As a result, we take initiative to introduce latest technologies and products to our country. Regular training and seminars are our contribution to society both intellectually and technologically.

- ✓ International Standard
- ✓ Industry Development
- ✓ Employee Education
- ✓ Joint Workshop
- ✓ Social Responsibility



ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЖ БҮЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ҮЙЛДВЭРЛЭЛД ЦАГ АЛДАЛГҮЙ НЭВТРҮҮЛЭХ


Дэлхийд шинээр нэвтэрч буй техник технологитой хөл нийлүүлэн алхахын тулд томоохон хэмжээний үзэсгэлэн яармагт инженер техник болон технологийн ажилчдаа идэвхтэй оролцуулж мэдэг боловсролыг нэмэгдүүлэх бодит арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллаж байна.

- ✓ Шинэ санаа
- ✓ Шинэ төг бүтээгдэхүүн үйлдвэртэй
- ✓ Салбартаа анхдагч

INTRODUCING DISRUPTIVE PRODUCTS & LATEST TECHNOLOGIES

In order to keep up with latest trends, our staffs are actively participating in large scale exhibitions and trainings.

- ✓ New Ideas
- ✓ Innovative Products
- ✓ First Mover in the Industry



Өндөр чанарын бетон зуурмаг / High quality RMC

Бид анх цагт 120 шоо метр бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтайгаар үйлдвэрлэлээ эхлүүлж байсан бол өдгөө 180 шоо метр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг нээж үйл ажиллагаагаа тэллээ. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагын хувьд хамгийн үнэт зүйл бол харилцагч байдаг. Тиймээс ч бид харилцагчиддаа бүтээгдэхүүнээ тасралтгүй нийлүүлэхийн тулд үйлдвэрээ төмөр замтай холбож, дүүргэгч материал болон холбогч материалыг нийлүүлэгчээс нь хурдан хугацаанд шууд татан авдаг боллоо.

Үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх гаднын нөлөөний гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2015 онд БНСУ-д үйлдвэрлэсэн цагт 40 тонн ууттай цемент задлах төхөөрөмжийг суурилуулж, цементийн нөөцийн сав /Село/-г 2018 онд 3 дахин нэмэхээр төлөвлөж байна энэ нь зуны ид ачааллын үед үүсдэг холбогч материалын тасалдлыг бүрэн зогсоох салбартаа одоогоор хэрэгжүүлээгүй томоохон үйлдвэрийн өргөжилт юм.

Бетоны чанарын гол үзүүлэлт болох ТЭМ түүний дараа эцсийн хэрэглэгчид очиж буй бүтээгдэхүүнийг өндөр хариуцлагатайгаар хянаж чанар стандартыг тогтмол барьж ажиллах ёстой байдаг. Ингэхийн тулд өндөр технологитой орчин үеийн багаж тоног төхөөрөмж шаардагддаг тул бид үүн дээр онцгой ач холбогдол өгч лабораторио бүрэн шинэчилсэн. Хоногт 3600м³ үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрээр нэг рейсийн 320м³ тээвэрлэх машин техникээр 60 метрийн зайд шахах боломжтой авто помпоор бетон цугалтыг өндөр төвшинд нийлүүлэн гүйцэтгэж байна.

- ✓ Орчин үеийн тоног төхөөрөмж
- ✓ Олон улсын стандарт
- ✓ Стандартчилагдсан үйлдвэр
- ✓ Үйл ажиллагааны тасалдалыг шийдсэн
- ✓ Цогц үйлдвэрлэлийн систем



We started operation with 120 m³/hour factory, but now we have opened new factory with production of 180 m³/hour. Client is our most valuable asset. Therefore, we build railroad to get raw materials to provide concrete anytime when it is necessary for customers. To increase productivity, we installed Korean 40 tons cement disassembly in 2015. In 2018, we planned to increase silo capacity by three times to prevent from raw material shortage during high peak in summer time.


To increase concrete durability, it is important to have high quality raw materials and to test concrete quality all the time. To do that, we updated our laboratory equipment with the latest products and introduced mobile laboratory for the first time. Afterwards, with our 3600 m³ capability per day plant, 320 m³ per trip mixers, 60 meters range of pump, we deliver concrete on time to our customers.

- ✓ Latest Equipment
- ✓ International Standard
- ✓ Standardized Plant
- ✓ Non-Operational Interruption
- ✓ Integrated Production System

ДАЙРГА

Манай карьер нь Сэлэнгэ аймгийн баянгол сумын баруун хараа Дархан уул аймгийн Дархан сумд байрлах MNS стандартыг хангасан барилгын өндөр даацын инженерийн төмөр бетон хийц эдлэл, төмөр замын далангийн элс хайрга дайргыг дараах 05-10мм, 10-20мм -ын пракцуудаар тус тус үйлдвэрлэж Улаанбаатар хот дахь өөрийн бетон зуурмагийн үйлдвэрт төмөр зам ашиглан нийлүүлэлтийг хийж та бүхэнд эцсийн бүтээгдэхүүн болгон хүргэж байна.

- ✓ Тасалдал үүсэхгүй
- ✓ Өндөр чанартай бүтээгдэхүүн
- ✓ Өөрийн карьерийн үйлдвэр



Дүүргэгч материалын татан авалт / Fine aggregate supply

STONE FACTORY

Stones, crushed with 05-10mm and 10-20mm, with the MNS (Mongolian) standards are transported by railroad from Darkhan City to our plant at the Ulaanbaatar city.

- ✓ Reliable Supply
- ✓ High Quality Products
- ✓ Our Own Raw Material Factory

ЭЛС

Барилгын MNS стандартын шаардлага бүрэн хангасан 0-5мм хүртэлх ширхэглэлтэй элсийг ашигладаг. Манай карьерын үйлдвэр нь элсний хамгийн чухал шаардлага болох бохирдол тоос шаварын хэмжээг багасгах зорилгоор 2 дахин угааж үйлдвэрлэлдээ нэвтрүүлдэг. Ингэж үйлдвэрлэлдээ нэвтрүүлснээр стандартад зөвшөөрөгдсөн бохирдлын хэмжээнээс 60%-80% хүртэл бууруулсан бүтээгдэхүүнийг ашигладаг. Манай бүтээгдэхүүнд агуулагдах цахиурын агууламжийн хэмжээ 65% -иас дээш байдаг нь бетон зуурмагийн чанарын гол үзүүлэлт болох шахалтын бат бэх-д эерэг нөлөөтэй байдаг.

- ✓ Тасалдал үүсэхгүй
- ✓ Өндөр чанартай бүтээгдэхүүн
- ✓ Өөрийн карьерийн үйлдвэр



Дүүргэгч материалын чанарын шинжилгээ / Quality test of fine aggregate

SAND FACTORY

Sand requirements are between 0 – 5mm in the MNS (Mongolian) standard for construction. Our quarry factory washes twice in order to minimize the pollution of dust, the most important requirement. Silicon content in our products is above 65%, which has a positive effect on the compressive strength.

- ✓ Reliable Supply
- ✓ High Quality Products
- ✓ Our Own Quarry Factory

НЭМЭЛТ


Гаднын нэмэлт бодисыг манай улсад нэвтрүүлэхэд олон талын судалгаа шинжилгээ хийгдсэн байх учиртай байдаг. Учир нь монгол орны цаг уур болон түүхий эд материалын шинж чанар нь бусад улсаас өөр байдаг тул үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нэн ярвигтай байдаг. Манай компаний хувьд евро стандартын шаардлага хангасан нэмэлт бодисыг олон удаагийн туршилт шинжилгээнд үндэслэн үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн.

- ✓ Харилцагчдын өндөр сэтгэл ханамж
- ✓ Найдвартай нийлүүлэлт
- ✓ Олон жилийн туршлагатай үйлдвэрлэл
- ✓ Олон удаагийн туршилт

ADMIXTURE

There is a need for multi-lateral research into the introduction of external extraneous substances into our country. Because of Mongolian harsh climate condition and raw materials, it is very difficult to create final product with admixture. Our company has introduced Euro-based additives for production based on multiple test and analysis.

- ✓ Customer Satisfaction
- ✓ Reliable Supply
- ✓ Highly Experienced
- ✓ Multiple Tests



Нэмэлтийн татан авалт / Admixture supply



ЦЕМЕНТ

MNS стандартын шаардлага хангасан барилга байгууламжид ашиглах ердийн Портланд PC32.5 , PC42.5, PC52.5 маркын цементийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэн ашиглаж байна. Тусгай зориулалтын бетон зуурмагийг харилцагчийн тавьсан шаардлага техникийн нөхцөлийн дагуу тусгай зориулалтын цементийг ашиглан хэрэглэгч болон хувь хүнд чанарын өндөр төвшинд бетон зуурмагийг нийлүүлж байна.

- ✓ Түүштай хамтын ажиллагаа
- ✓ Цөөн тооны итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчидтэй
- ✓ Татан авалт бүрийн тогтмол шинжилгээ



CEMENT


The conventional Portland PC32.5, PC42.5 and PC52.5 conveying cement are used in buildings that meet the MNS (Mongolian) standard requirements. Depending on client's needs, we tailor each product with high quality cements.

- ✓ Long Term Based Cooperation
- ✓ Reliable Supplier
- ✓ Regular Tests



Манай компани бүтээгдэхүүнд орж буй бүхий л түүхий эд материалыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхээс өмнөх үеийн судалгаа туршилтаас үндэслэн эцсийн хэрэглэгчид нийлүүлсний дараах хяналт хүртэлх чанарыг, шинэ дэвшилтэт техник технологийг үндэслэн туршлагатай баг хамт олны туршлагаар шинжилж бүхий л үйл явцыг стандартын дагуу хянаж, залруулж үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагаагаа улам тэлэхийн тулд олон улсаас сургалт семинарыг авч, дотоодын мэргэжилтнүүд, зөвлөхүүдтэйгээ ойр ажиллаж өөрсдийн мэдлэгийн хүрээ туршлагаа нэмэгдүүлж байна.


Our company reviews and analyzes quality of all raw materials from purchase to the production. If any error occurs, we stop to fix problems. To expand operations and experience, we have been participating in international workshops and cooperating with local specialists and consultants.



Чанарын баталгаа

100 жилийн баталгаатай чанартай бетон зуурмагийг үйлдвэрлэхийн тулд бүхий л материалыг тестлэх, шинжлэх цогц лаборатори байх ёстой. Олон улсын технологийн дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж чанар технологиор стандарт тогтоосон дэлхийд тэргүүлэгч компаниудын нэг болох "Proceq" брендийн багаж тоног төхөөрөмжийг мөн адил нэвтрүүлж чадсан. Гаднаас мэргэшсэн экспертүүдийг урьж авчран тогтмол туршлага солилцож бетон зуурмагийн гол хүчин зүйл болсон технологийн дэвшлийг хөгжүүлэх тал дээр өндөр ач холбогдол өгч байна. Эцэстээ салбартаа тохиолддог хүндхэн асуудлуудыг цаг алдалгүй шийдэх тал дээр тогтмол судалгаа шинжилгээ хийж дүгнэлт гаргах, улсын лабораторитой мэдээлэл туршлагаа тухай бүрт солилцож мэдлэгээ дээшлүүлэн бүрэн "итгэмжлэгдсэн лабораторийг бий болгох зорилгын доор санаа нэгдэн ажиллаж байна.

- ✓ Орчин үеийн тоног төхөөрөмж
- ✓ Шинэ шинэлэг технологи
- ✓ Олон улсын хамтын ажиллагаа
- ✓ Олон жилийн туршлагатай баг хамт олон
- ✓ Олон удаагийн туршилт шинжилгээ
- ✓ Шинэ санаа



There should be a comprehensive laboratory for testing all materials to produce 100-years quality concrete. We regularly invite foreign and internal experts to train our technologists and update our laboratory equipment. Ultimately, we are planning to become "fully accredited laboratory" and to do that, technologists learn from state laboratory and experts.


- ✓ Latest Equipment
- ✓ Innovative Technologies
- ✓ International Cooperation
- ✓ Experienced Team
- ✓ Multiple Tests
- ✓ New Ideas



МАШИН ТЕХНИК, ТЭЭВЭРЛЭЛТ

Манай компани харилцагчиддаа бүтээгдэхүүн нийлүүлэхэд үүсдэг тасалдал, зогсолтоос урьдчилан сэргийлэх үүднээс өөрийн 23 ширхэг миксер /NRMCA гэрчилгээтэй / гэрээт 20 иод миксертэй хамтран ажиллаж захиалагч талын бүтээгдэхүүнийг захиалсан хугацаанд нь бүрэн нийлүүлж өндөр гүйцэтгэлтэй хамтран ажиллаж байна. Тээвэрлэлт хийх жолооч бүрд замын хөдөлгөөнд зөв боловсон оролцох, аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд зэргээр сургалтыг тогтмол орж жолооч бүрийг мэргэшсэн жолооны сургалтад хамруулж дадлагажуулан тээвэрлэлтийг онц аюулгүй хүргэн нийлүүлдэг. Манайхаас бетон захиалсан тохиолдолд үйлдвэрлээд өөрийн төсөлд буулгах үеийн бүхий л хяналтыг манай “Цахим онлайн систем” –ээс харах болон жолоочтой RFID богино холбооны станцыг ашиглан холбогдох боломжтой.

- ✓ Шууд харилцаа
- ✓ Бүх үеийн хяналт
- ✓ Мэргэшсэн жолооч
- ✓ Найдвартай нийлүүлэлт
- ✓ Ашиглах хугацаа ихтэй баталгаат засвартай машин техник



TRANSPORTATION

Our company owns 30 mixing machines certified with NRMCA certification, and cooperates with contracted 20 mixers that is fully committed to delivering customer's orders. Each driver is responsible for obeying traffic law and driving safely, and drivers are trained in safe transportation training courses. A client can both see drivers' location (with GPS) from online system and can contact by radio stations.

- ✓ Direct Communication
- ✓ Real Time Location Tracker
- ✓ Qualified Drivers
- ✓ Reliable Supply
- ✓ Vehicles with Warranty



ДҮҮРГЭГЧ МАТЕРИАЛ ТЭЭВЭРЛЭГЧ


Ихэнх тохиолдолд дүүргэгч материалыг төмөр замаар шийддэг ба шаардлагатай тохиолдолд өөрийн эзэмшлийн 20 м³ ачих багтаамжтай 5 ширхэг хова машинаар нэг удаагийн 100м³ бүтээгдэхүүнийг тээвэрлэж гүйцэтгэдэг. Төмөр замаар нийлүүлэлт хийхэд бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тасралт үүсэх нь бага байдаг.

- ✓ Тасалдалгүй нийлүүлэлт
- ✓ Туршлагатай жолооч
- ✓ Авто зам ашиглалт бага /Жижиг ангилагчийн хайрга зам дээр унагаах эрсдэл/

AGGREGATE MATERIAL CARRIER

In most cases, aggregate material is transported by railroad. If there's a shortage problem, 100m³ aggregate will be transported by 5 trucks with a load of 20 m³ each. However, railroad supply is reliable most of the time.

- ✓ Uninterrupted Delivery
- ✓ Qualified Drivers
- ✓ Low Road Usage



АВТО ПОМП


Үйлдвэрлэсэн бетон зуурмагийг захиалагч талын төсөлд 44метр, 52метр, 60метрийн зайд шахах хүчин чадал бүхий Zoomlion брэндийн ECP44-60CS-5 төрлийн авто помпыг ашиглан мэргэшсэн туршлагатай операторуудын цугалтыг гүйцэтгэж өгнө. Операторууд 10 жилийн туршлагатай ба жил бүр сургалт семинарт тогтмол оролцож ажиллах үеийн ХАБ –ын зөвлөгөөг өглөө бүр авч ажилладаг. Захиалагчдын хүсэлтээр шаардлагатай тохиолдолд суурин помпоор захиалгын дагуу үйлчилгээ үзүүлэх бүрэн боломжтой.

- ✓ Олон жилийн туршлага
- ✓ Хамгийн өндөр авто помп
- ✓ Төлбөрийн уян хатан нөхцөл
- ✓ Ашигласан хугацаа бага
- ✓ Таны хүссэн цагт үйлчлэх боломжтой

AUTO PUMP

Experienced operator controls Zoomlion ECP44-60CS-5 pump with a capability of 44 meters, 52 meters and 60 meters. Operators have 10 years of experience and regularly attend trainings. With customer's request, it is also possible to provide a service based on order.

- ✓ Experienced Team
- ✓ Variety of Auto Pumps
- ✓ Flexible Payment Terms
- ✓ Time Saving
- ✓ Available at Your Desired Time




Компанийнхаа үнэт зүйлс болон ёс зүйн зан төлөвийг зохистойгоор баримтлан ажиллахыг хичээн ажилладаг. Манай ажилтнуудын ёс зүй нь аюулгүй ажиллагаа, хичээл зүтгэл, боловсрон хөгжих, хамтын ажиллагаа, хариуцлага дээр суурилдаг. Нийгмийн хариуцлагыг ухамсарлаж монгол улсдаа 80 гаруй ажилтныг тухайн чиглэлээр нь хөгжүүлэн мэргэшүүлж, туршлага хуримтлуулах явцад хичээнгүйлэн зүтгэж байна. Бидний гол үнэт зүйл болсон ажилчдын мэдлэг үр чадварыг ашиглах биш улам хөгжүүлж цаашдаа олж авсан туршлагаа улам баяжуулж өөрийнхөө амьдралын үнэт уурхай болгоосой гэсэндээ тогтмол гаднаас туршлага солилцох ажлыг хийж байна. Компанийн ажилтан бүр эрхэлсэн ажилдаа чин сэтгэлээсээ хандаж, үргэлж шинийг эрэлхийлэн ажиллаж, үр дүнтэй ажиллаж, хөдөлмөрийн үр дүнгээ бодитойгоор үнэлүүлэх нэгдсэн системийг хамтран бүрдүүлнэ.

- ✓ Чадварлаг хамт олон
- ✓ Багийн ажиллагаа
- ✓ Олон жилийн туршлага
- ✓ Хувь хүний хөгжил
- ✓ Ёс зүй
- ✓ Нийгмийн хариуцлага

We strive to maintain our company's values and ethics. Safety is the most important part for us. Therefore, we have been working hard to develop socially responsible 80 employees. Our main objective is to keep improving employee skills by external and internal training. As a result, this system is all about passionate, trained, skilled employees, who can work as one team.

- ✓ Skilled Colleagues
- ✓ Teamwork
- ✓ Experienced Team
- ✓ Self Development
- ✓ Ethic
- ✓ Social Responsibility





Дэлхий нийтээрээ цааснаас татгалзаж онлайн системд шилжиж байна. Бүхий л томоохон компаниуд технологийн хурдтай хөгжилд хөл нийлүүлэн алхахын тулд цаг алдалгүй цахим системийг өөрсдийн үйл ажиллагаанд зохицуулан бий болгож нэвтэрч эхэлсээр байна. Бид ч мөн адил 2015 оноос энэ системийг нэвтрүүлж эхэлсэн. Хэрэглэгч та манайхаас бетон зуурмаг худалдан авахдаа өөрийнхөө гар утсан дээрээс бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэхээс аваад барилга дээр цутгалт хийх хүртэлх бүх ажиллагааг видео камер, Жи Пи Эс аппликейшнийн тусламжтайгаар харах, хянах бүрэн боломжтой. Мөн цутгалтын ажлын гүйцэтгэлийн хувь, санхүүгийн төлбөр тооцоо, чанар стандартын үзүүлэлтүүд зэргийг гар утаснаасаа шууд үзэх боломж нээгдсэн гэсэн үг. Захиалагч таны харахыг хүссэн бүхий л мэдээллүүдийг та нэгхэн товч дараад харах боломжтой болж байна.

- ✓ Шууд хяналт
- ✓ Нийлүүлэлтийн үеийн үйлдвэрлэлтийн процесс
- ✓ Санхүүгийн бүхий л мэдээллүүд
- ✓ машин техникийн хүргэлтийн процесс
- ✓ Дэвшилтэт хамтын ажиллагаа
- ✓ Чанар стандартын үзүүлэлтийг гар утаснаасаа
- ✓ Орчин үеийн систем
- ✓ Хүссэн үедээ бүхий л мэдээллийг нэг дороос

Traditional paper usage is now transforming into online system. All major companies are in the process of changing to the online system. We started introducing our own system since 2015. After purchase contract signed, clients have access to all activities, such as, concrete delivery percentage, mixer tracking system. Moreover, with smart phone, clients have access to contract, payment, and quality control. With just one touch, a client has access to everything.

- ✓ Direct Control
- ✓ Supplied Rate
- ✓ Financial Information
- ✓ Mixer Delivery Process
- ✓ Advanced Cooperation
- ✓ Quality Standards
- ✓ Advanced System
- ✓ One touch, simple access



Гэрээт захиалгууд					
Захиалгын статус	Гэрээт компани	Бүтээгдэхүүний төрөл	Гэрээний дугаар	Захиалгын огноо	
Сонгоно уу	Сонгоно уу	Сонгоно уу			Хайх
Захиалга нэмэх					
Компаний нэр	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжээ	Захиалгын дүн	Гэрээний дүн	Захиалгын огноо
Teso Construcion Захиалгын №: AG2018-2 Статус: Үйлдвэрлэж эхэлсэн	Гэрээ №: HUN-HU-98 Утас: 991111 M400 I B25 I C30 I F35 Слампыг: Slump I 20	600 - 605 м³ Явц: 17% (100 м³)	Мөнгөн дүн: 0 ₮ сонгосноор үнэ тооцогдох болно Нэмэлт төлбөр: 0.00 ₮ Нийт захиалгын дүн: 0 ₮ Төлбөр: Гэрээний дагуу	Мөнгөн дүн: 0 ₮ Нэмэлт төлбөрийн дүн: 0 ₮ Помпын төлбөрийн дүн: 0 ₮ Нийт: 0 ₮ Төлсөн: 550,000,000.00 ₮ Үлдэгдэл: 0 ₮	2017-09-14 Цаг: 08:00 Захиалаа өгсөн: 2018-02-13 12:18:56
Teso Construcion Захиалгын №: AG2018-1 Статус: Үйлдвэрлэж дууссан	Гэрээ №: HUN-HU-98 Утас: 991111 M300 I B25 I C30 I F35 Слампыг: Slump I 19	500 - 500 м³ Явц: 100% (500 м³)	Мөнгөн дүн: 0 ₮ сонгосноор үнэ тооцогдох болно Нэмэлт төлбөр: 0.00 ₮ Нийт захиалгын дүн: 0 ₮ Төлбөр: Гэрээний дагуу	Мөнгөн дүн: 0 ₮ Нэмэлт төлбөрийн дүн: 0 ₮ Помпын төлбөрийн дүн: 0 ₮ Нийт: 0 ₮ Төлсөн: 5 Үлдэгдэл: 0 ₮	2017-09-11 Цаг: 11:00 Захиалаа өгсөн: 2018-02-07 15:51:13

Манай компани 2011 онд албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба өдий хүртэл шат шатаар ахиж харилцагч бүрд өндрөөр үнэлэгдсэний хүчинд одоогоор хэрэгжиж буй улсын болон хувийн томоохон төслүүдэд үр ухаанаа шингээсэн, чанартай бүтээгдэхүүнийг нийлүүлсээр байна.

Манайхыг сонгож хамтран ажиллаж байгаа нийт харилцагчиддаа
БАЯРЛАЛАА.

Since founded in 2011, we have been supplying quality products and services to large public and private projects.

Thank you to all of our clients for choosing our company.



"ТЭСО констракшн"-аас хэрэгжүүлж байгаа "Содон Хороолол"



"ТЭСО констракшн"-аас 2018 онд бүтээн байгуулалт нь эхлэх "Skygarden" төсөл



